



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн
Ерөнхий захирал: Т.Батсайхан
Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com
Аудитын менежер: Г.Оюунгэрэл
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com
Ахлах аудитор: О.Хосбаяр
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУС	Боловсрол шинжлэх ухаан сайд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХЗГБХГ	Хүүхэд залуучуудыг гэт бүлэглэлээс хамгаалах газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/173
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Н.СОЁЛ-ЭРДЭНЭ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,516,699.31	113,666,187.31
35	БАРАА МАТЕРИАЛ	78,516,699.31	113,666,187.31
351	Түүхий эд материал	9,074,081.80	8,999,231.80
35110	Тусгай зориулалттай материал	7,606,981.80	7,606,981.80
35130	Эм боох материал	1,467,100.00	1,392,250.00
354	Хангамжийн материал	69,442,617.51	104,666,955.51
35410	Бичиг хэргийн материал	440,000.00	2,565,000.00
35420	Аж ахуйн материал	13,544,443.80	26,079,743.80
35440	Түлш, шатах тослох материал	5,266,632.00	2,887,230.00
35450	Барилгын засварын материал	1,815,980.00	5,415,980.00
35460	Хүнсний материал	7,207,100.00	18,364,840.00
35470	Бусад хангамжийн материал	41,168,461.71	49,354,161.71
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	609,309,964.56	599,609,419.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	609,309,964.56	599,609,419.37
392	Биет хөрөнгө	595,463,964.56	585,837,898.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	634,693,678.52	603,646,278.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	-69,936,342.46	-54,960,087.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,368,310.00	45,612,108.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,546,533.28	-22,603,928.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,429,840.00	18,629,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,235,627.02	-13,177,523.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,896,445.00	12,296,445.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,210,627.20	-6,610,055.20
39217	Ном	3,004,821.00	3,004,821.00
393	Биет бус хөрөнгө	13,846,000.00	13,771,520.95
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-899,479.05
39303	Бусад биет бус хөрөнгө	13,846,000.00	13,846,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	687,826,663.87	713,275,606.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	300,528.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	300,528.95
413	Өглөг	00.00	300,528.95
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	300,528.95
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	687,826,663.87	709,459,538.45
51	Засгийн газрын хувь оролцоо	687,826,663.87	709,459,538.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	718,274,790.00	718,274,790.00
51101	Өмч: - төрийн	718,274,790.00	718,274,790.00
512	Хуримтлагдсан үр дүн	-59,314,700.68	-32,236,948.10
51210	Өмнөх үеийн үр дүн	-59,314,700.68	-53,869,822.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	21,632,874.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,866,574.55	23,421,696.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	687,826,663.87	709,760,067.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	461,911,810.00	470,876,798.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,529,110.00	12,474,598.08
120	Нийтлэг татварын бус орлого	7,529,110.00	12,474,598.08

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,529,110.00	12,474,598.08
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,529,110.00	12,474,598.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	454,382,700.00	458,402,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434,069,800.00	431,300,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	461,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	461,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,312,900.00	26,640,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,312,900.00	26,640,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	430,035,931.36	449,203,423.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	430,035,931.36	449,203,423.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,055,231.36	449,203,423.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,975,239.52	328,667,881.23
210101	Үндсэн цалин	303,975,239.52	328,667,881.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,189,990.48	42,605,887.00
210201	Тэтгэврийн даатгал	25,742,746.82	29,582,480.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,028,559.39	3,283,856.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,422,846.51	2,627,085.00
210204	Ажилгүйдлийн даатгал	532,210.64	638,466.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,463,627.12	6,474,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,772,119.60	20,136,402.00
210301	Гэрэл, цахилгаан	2,827,268.00	2,581,870.00
210302	Түлш, халаалт	9,928,229.60	15,954,532.00
210303	Цэвэр, бохир ус	2,016,622.00	1,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,548,368.40	6,667,300.00
210401	Бичиг хэрэг	1,105,500.00	286,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,268,568.40	2,343,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	337,900.00	486,300.00
210404	Ном, хэвлэл	118,000.00	238,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,284,500.00	3,313,200.00
2105	Нормативт зардал	32,597,700.00	21,779,510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	904,900.00	612,750.00
210502	Хоол, хүнс	31,692,800.00	21,166,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,727,300.00
210604	Урсгал засвар	00.00	2,727,300.00
2107	Томилолт, зочны зардал	56,000.00	238,500.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	238,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	1,481,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,181,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,615,813.36	24,898,943.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	519,800.00	62,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,272,300.00	4,691,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,823,713.36	20,144,343.27

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	31,875,878.64	21,673,374.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	40,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	40,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-40,500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	31,875,878.64	21,632,874.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	454,382,700.00	458,402,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	454,382,700.00	458,402,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434,069,800.00	431,300,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	461,800.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,312,900.00	26,640,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,312,900.00	26,640,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	445,747,700.00	451,702,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,747,700.00	451,702,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,767,000.00	451,702,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,733,000.00	327,275,079.00
210101	Үндсэн цалин	255,710,600.00	238,794,179.00
210102	Нэмэгдэл	24,466,900.00	67,925,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	20,555,500.00	20,555,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,037,300.00	40,182,621.00
210201	Тэтгэврийн даатгал	27,939,300.00	27,764,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,024,500.00	2,984,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,419,600.00	2,387,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	604,900.00	596,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,049,000.00	6,449,821.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,000,000.00	18,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,827,268.00	2,581,870.00
210302	Түлш, халаалт	13,172,732.00	13,418,130.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00

2104	Хангамж, бараа материалын зардал	17,461,400.00	8,348,800.00
210401	Бичиг хэрэг	1,037,900.00	286,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	337,900.00	486,300.00
210404	Ном, хэвлэл	489,900.00	238,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,360,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,735,700.00	4,837,700.00
2105	Норматив зардал	56,895,700.00	33,835,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,696,000.00	557,200.00
210502	Хоол, хүнс	38,899,900.00	32,324,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,299,800.00	954,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	265,000.00	14,807,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	265,000.00	3,680,000.00
210602	Тавилга	00.00	4,800,000.00
210604	Урсгал засвар	00.00	6,327,300.00
2107	Томилолт, зочны зардал	56,000.00	238,500.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	238,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	1,481,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,181,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,018,600.00	7,532,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	719,800.00	715,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,298,800.00	6,816,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,980,700.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>8,635,000.00</u>	<u>6,700,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,635,000.00	6,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,635,000.00	6,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,635,000.00	6,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,635,000.00	6,700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-8,635,000.00</u>	<u>-6,700,000.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	718,274,790.00	28,866,574.55	-91,210,579.32	655,930,785.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	718,274,790.00	28,866,574.55	-91,210,579.32	655,930,785.23
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	31,875,878.64	31,875,878.64
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	718,274,790.00	28,866,574.55	-59,314,700.68	687,826,663.87
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	718,274,790.00	28,866,574.55	-59,314,700.68	687,826,663.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,444,878.00	5,444,878.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	718,274,790.00	28,866,574.55	-53,869,822.68	693,271,541.87
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-5,444,878.00	00.00	-5,444,878.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,632,874.58	21,632,874.58
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	718,274,790.00	23,421,696.55	-32,236,948.10	709,459,538.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	457,940,400.00	457,940,400.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	457,940,400.00	457,940,400.00	-	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРД	457,940,400.00	457,940,400.00	-	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,306,500.00	327,275,079.00	968,579.00	100.30
210101	Үндсэн цалин	237,825,600.00	238,794,179.00	968,579.00	100.41
210102	Нэмэгдэл	67,925,400.00	67,925,400.00	-	100.00
210104	Урамшуулал	20,555,500.00	20,555,500.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,051,400.00	40,182,621.00	(3,868,779.00)	91.22
210201	Тэтгэврийн даатгал	30,999,100.00	27,764,400.00	(3,234,700.00)	89.57
210202	Тэтгэмжийн даатгал	3,263,100.00	2,984,200.00	(278,900.00)	91.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,610,500.00	2,387,500.00	(223,000.00)	91.46
210204	Ажилгүйдлийн даатгал	652,600.00	596,700.00	(55,900.00)	91.43

210205	Эрүүл мэндийн даатгал	6,526,100.00	6,449,821.00	(76,279.00)	98.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,000,000.00	18,000,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	2,581,870.00	(2,418,130.00)	51.64
210302	Түлш, халаалт	11,000,000.00	13,418,130.00	2,418,130.00	121.98
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,348,800.00	8,348,800.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	286,300.00	286,300.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	486,300.00	486,300.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	238,500.00	238,500.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,837,700.00	4,837,700.00	-	100.00
2105	Нормативт зардал	30,673,900.00	33,574,100.00	2,900,200.00	109.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	295,400.00	295,400.00	-	100.00
210502	Хоол, хүнс	29,424,300.00	32,324,500.00	2,900,200.00	109.86
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	954,200.00	954,200.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,507,300.00	21,507,300.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,180,000.00	6,180,000.00	-	100.00
210602	Тавилга	9,000,000.00	9,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	6,327,300.00	6,327,300.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	238,500.00	238,500.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	238,500.00	238,500.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,281,700.00	1,281,700.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	981,700.00	981,700.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,532,300.00	7,532,300.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	715,600.00	715,600.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,816,700.00	6,816,700.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	457,940,400.00	457,940,400.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	433,613,100.00	431,300,200.00	(2,312,900.00)	99.47
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	433,613,100.00	431,300,200.00	(2,312,900.00)	99.47
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,327,300.00	26,640,200.00	2,312,900.00	109.51
132001	Орон нутгийн төсвөөс	24,327,300.00	26,640,200.00	2,312,900.00	109.51
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.00	29.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	461,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461,800.00
2105	Нормативт зардал	261,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	261,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	461,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	461,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, дотоод хяналттай холбоотойгоор 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн аудитор О.Хосбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго "Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино" гэж тодорхойлжээ

Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа;
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 450-р тогтоолоор Хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын нормативыг 2475 төгрөгөөр тогтоосон.
- Нэмэгдэл цалин хөлс олгох тухай 2018 оны 382-р тогтоолын 1,2,5,6,7 дугаар хавсралт, Засгийн газрын 2020 оны 4-р сарын 29-ний өдрийн 151-р тогтоол,
- Засгийн газрын 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн 472 -р тогтоол “ Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай байна. Тус байгууллага дотоод хяналтын журам заавар байхгүй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Харин дотоод хяналтыг зөвхөн сургалтын үйл ажиллагаа, анги танхимын эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэнд, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 430, сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 430.0 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 8,6 төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагаан-Үүр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25.5 сая төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна. Өмнөх мөн үеэс бараа материал 35.1 сая өссөн бол биет хөрөнгө 9.6 сая, хуримтлагдсан үр дүн 27.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	78.5	113.7	35.1
Биет хөрөнгө	595.5	585.8	(9.6)
Биет бус хөрөнгө	13.8	13.8	0
Нийт хөрөнгө	687.8	713.3	25.4
Хуримтлагдсан үр дүн	-59.3	-32,2	(27.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	687.8	713.3	25.4

Бараа материалын дансны үлдэгдлийн материаллаг өөрчлөлт:

1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан бараа материал 77.8 сая,
2. Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2022 оны 1 сарын 14-ний өдрийн 27 тоот албан бичгээр БШУЯ -ны хөрөнгө оруулалтаар 2.9 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын иж бүрдлийг хуваарилсан байна.
3. Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 сарын 9 сарын 24-ний 03 тоот албан бичгээр 4.5 сая төгрөгийн хөгжмийн хэрэгсэл хуваарилсан байна.
4. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 08 сарын 27-ны өдрийн А/390 тоот албан бичгээр 0.92 сая төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн материалыг хуваарилсан.
5. Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 9 сарын 10-ны өдрийн А/97 тоот албан бичгээр Боловсрол соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 3.7 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж эрх шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд 51.4 сая бараа материал зарцуулсан байна. Тайлант хугацаанд нэлээд хэмжээний худалдан авалт хийснээс бараа материалын нөөц 35.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл -32.2 сая төгрөг болж өнгөрсөн оноос 0,027 сая төгрөгөөр сайжирсан нь тайлант онд ашигтай ажилласантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 440,9 сая, орон нутгийн төсвөөс 20.7 сая, нийт 461.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын Иргэдийн Хурлын 2020 оны 12 сарын 18-ны өдрийн 04 тоот тогтоолоор 2021 оны төсвийг 461.6 сая төгрөгөөр баталсан бол 2021 оны 9 сарын 24-ний өдрийн 03 тоот тогтоолоор төсвийг 3.7 сая төгрөгөөр бууруулан нийт 457.9 сая төгрөгөөр баталжээ. Үүнд: Тусгай зориулалтын шилжүүлгээс 433.6 сая, орон нутгийн төсвөөс 24.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн.

2021 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг энэ тайлангийн 2.5 -д дэлгэрэнгүй харууллаа.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 433.6 сая, орон нутгийн төсвөөс 24.3 сая нийт 457.9 сая төгрөгийн санхүүжилт авч төлөвлөсөн төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан. Тайлант хугацаанд цалингийн зардал 0.9 сая, хоол хүнсний зардал 2.9 сая төгрөгөөр хэтэрсэн бол ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 3.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн энэ хэлбэлзэл нь төсвийн төлөвлөгөөг тооцоо судалгаа муутай боловсруулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2021 оны 9 сарын 15-ны өдрийн А/40 тоот албан бичгээр 0.3 сая төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн зардлын санхүүжилт хуваарилсан. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 10 сарын 8-ны А/99 тоот тушаалаар “Хүрэхүй” хөтөлбөрийг сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хэрэгжүүлэх ажлын хүрээнд олгосон шагнал урамшууллын зардалд 0.2 сая төгрөг тус тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрснийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Корона вирус -2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас хамрагдах хүүхдийн тоо буурч, үйлчилгээ хязгаарлагдмал байсан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан

нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно

3.8 Аудитын гол асуудал

Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэх дорвитой ажил зохион байгуулаагүй учир арвилан хэмнэлт гараагүй байна. Гэхдээ тайлант оны тодотгосон төсвөөр анхны төсвийг 3.7 сая төгрөгөөр бууруулан баталсан учир уг төсвийг хэмнэх нөөц бололцоо бага байна.

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно,

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 995.3 сая төгрөгийн 70 мэдээллээс 995.3 сая төгрөгийн 70 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн хүүхдийн хоолны зардлын нормативын хэрэгжилтийг шалгалаа.

Засгийн газрын 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолоор хүүхдийн хоолны зардлын нормативыг 2475 төгрөгөөр тогтоосон нэг хүүхдэд ногдох үдийн хоолны нормативд зардлыг хэтрүүлээгүй нь уг тогтоолын холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Мөнгө нөөц баялаг аудит ХХК тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж 2 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

1. Төсөвт зохицуулалт хийх шаардлага, нарийвчилсан тооцоо тайлбар хийсэн баримт бичгийг бүрдүүлж, нөөцийг тооцож их хэмжээний нөөц үүсгэхгүй байх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Энэ онд бараа материалын нөөц 35.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 24.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3.1 сая төгрөгийн тавилга хэрэгсэл нийт 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож ашиглах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 545.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 517.4 сая төгрөгийн алдааг залруулж, 27.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 517,4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулав.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

1.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн "0" үлдэгдэлтэй 24.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3.1 сая төгрөгийн тавилга хэрэгсэл нийт 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож ашиглах тухай зөвлөмжийг хэрэгжүүлэх.

1.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө нийт 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. УСНББОУС -ын Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний загвар хэсэгт заасан удирдамж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.5. Энэхүү журмын 1.4 д зааснаас бусад тохиолдолд Дотоод хяналтыг зохион байгуулах журмыг тухайн байгууллага аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтын журам боловсруулж, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЦАГААН-ҮҮР сумын Хүүхдийн цэцэрлэг	3	545.2	1	517.4	-	-	-	-	2	27.8